

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2020.02.04

Тендер шалгаруулалтын нэр: **Хужирт сумын Эрүүл мэндийн төвийн эмчилгээний хоол, хүнсний материал нийлүүлэх тендер**

Тендер шалгаруулалтын дугаар: **№ ӨВАХУСЗДТГ/202001009**

Өвөрхангай Хужирт сумын Засаг даргын Тамгын газар нь эрх бүхий тендерт оролцогчдоос **“Хужирт сумын Эрүүл мэндийн төвд эмчилгээний хоол, хүнсний материал”-ыг** нийлүүлэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү барааны тендер шалгаруулалт нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу. Тендер шалгаруулалтын Сангийн сайдын 2013 оны 07 дугаар тушаалаар батлагдсан “Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журам”-ын дагуу зохион байгуулж байна.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө **50.000 /тавин мянга/** төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **45** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Борлуулалтын хэмжээ: **Сүүлийн 2 жилийн дундаж нь санал болгож буй үнийн дүнгийн 50%-аас багагүй байна.**

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: **Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 оны аудитлагдсан санхүүгийн тайлан**

Сүүлийн хоёр жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: **Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 онуудын аль нэг жилд ижил төстэй бараа нийлүүлсэн туршлагатай байх.**

Тендерийг **2020 оны 2 дугаар сарын 11-ны өдрийн 15 цаг 00** минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2020 оны 2 дугаар сарын 11-ны өдрийн 15 цаг 30** минутад нээнэ.

Монгол Улсын гарал үүсэлтэй бараанд давуу эрхийн зөрүү тооцно.

Төлбөрийн хийх хэлбэр: **Цахим**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Өвөрхангай аймгийн Хужирт сумын Засаг даргын Тамгын газар, 2 давхар 11 тоот Утас:80010404